

БАТНАВ
ЗАСАГ ДАРГА Д.ЭРДЭНЭЖАРГАЛ

ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ ГҮН ӨРМИЙН ХУДГИЙН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Захиалагч: Говь-Алтай аймгийн Алтай сумын ЗДТГ
2. Шаардагдах хөрөнгө: 70 сая төгрөг
3. Санхүүжилт: ОНХС-ын хөрөнгөөр
4. Худгийн тоо: 2
5. Тавигдах шаардлага:

Говь-Алтай аймгийн Алтай сумын Урт, Бадрал багуудын нутаг дэвсгэрт гүн өрмийн худаг шинээр гаргах ажлыг гүйцэтгэхэд худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS 6088:2011, худгийн цооногийн хийц, зохиомж, барилгын ажлыг MNS 6088:2010 стандартыг мөрдлөг болгон доорхи нөхцөлийг хангаж ажиллана.

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
1. ЦООНОГ ӨРӨМДӨХ, ЦООНОГИЙГ ТОНОГЛОХ		
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох Уст цэгийн геоцахилгаан зүсэлтийг хавсралтын дагуу бэлтгэх. Усгүй буюу хэт бага устай гэж тодорхойлогдсон газар өрөмдөж илүү зардал гаргахгүй байхад анхаарах	
1.2	Цооногийн ашиглалтын ундарга: нэг цагт 2- м3, /0,6л/с-ээс 1,8л/с/ доошгүй байх	
1.3.	Суултын яндангийн материал нь ган хоолой байна.	
1.4.	Шүүрийн яндангийн материал нь ган хоолой байна	
1.5	Ус өргөх яндангийн диаметр 30мм-ээс багагүй залгаасгүй байна.	
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 9мм-ээс томгүй байна.	
1.7	Тунгаагуурын гүн: 2м-ээс багагүй	
1.8	Худгийг шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 24 цагаас багагүй	
1.9	Усны чанарын сорилт авах шинжилгээ хийлгэх	
1.10	Худгийг түр хугацааны тагаар тоноглох	
1.11	Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь: 60мм диаметртэй, гаднах ханаас 2м урттай гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргах	
1.12	Ундны ус авах хоолой нь: 60мм диаметртэй, ган хоолойг цонхны доор гаргах /ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох/	
2. ХУДГИЙН НАСОС, ГЕНЕРАТОР, ЦАХИЛГААНЫ УТАС, ХЯНАХ САМБАР		
2.1	Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан. Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх.	
2.2	Цахилгааны утас: 3-4 салаа, ус чийгний хамгаалалтай, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн	

	(залгаасгүй), ус өргөх янданд 2м тутамд хавчиж (туузаар ороож болохгүй) тогтооно.	
2.3	Хянах самбар: Асаах, унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан / гэрлээр асаах индикатортой, насос ажиллуулах асаагууртай,	
2.4	Бага оврын генератор: Бензинээр ажилладаг /ISO стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах	
3. ХУДГИЙН БАРИЛГА		
3.1	Худгийн барилгын дотор багтаамж нь 18м ³ –ээс багагүй дотор талдаа усан сан, халаах зуух, цооногоос усан сан, усан сангаас мал услах онгоц руу ус дамжуулах хоолойтой, барилга нь гадна талдаа хаявчтай, төмрөөр дээвэрлэсэн байна.	
3.2	Худгийн моторын яндан заавал худгийн барилгаас гадагш гаргах эсвэл цонхтой байх, худгийн хаалгыг салхи уруу харуулах, худагт 40:40 см хэмжээтэй цонх гаргана.	
	Мал услах онгоц нь 9м-ээс багагүй урттай, 400 мм-ийн голчтой хагас цилиндр ган яндан буюу цутгамал төмөр бетоноор хийж, мал услах онгоцны хоёр талд 0,5 м өргөнтэй цементэн хавтангаар талбайг бат бөх суурилуулна.	
4. ХУДГИЙН АЖЛЫГ ДУУСГАЖ ХҮЛЭЭЛГЭЖ ӨГӨХ		
4.1	Худгийн техникийн паспортыг хөтөлж сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгөх	
4.2	Худаг, гүний насос, жижиг оврын генераторыг ажиллуулах, үйлчилгээ хийх талбайн сургалт хийх	
4.3	Талбайг цэвэрлэх /өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал гэх мэт/	

БОЛОВСРУУЛСАН:
ХАА-Н ТАСГИЙН ДАРГА *Бесер* Б.БУЯНДЭЛГЭР